



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/307

Булган сум

### Г “Мэдээлэх самбар” байрлуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, Хууль зүй дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдаагийн өрөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны “Санал хүргүүлэх тухай” хүсэлтийн дагуу зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг бууруулах зорилгоор (олон улсын) улсын болон орон нутгийн чанартай авто замд хөдөлгөөнд оролцож байгаа иргэд, жолооч нарт тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн хурдыг Замын хөдөлгөөний дүрэмд заасан хязгаараас хэтрүүлэхгүй байх талаар “Мэдээлэх самбар” байрлуулахад 8,500,000 (найман сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, зардлын тооцоо, гүйцэтгэлийг гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр), хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү) тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

